

“АСБИ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04 сарын 11

Дугаар 01

Улаанбаатар хот

“АСБИ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04-р сарын 11-ны өдрийн Пүрэв гаригт 10.00 цагт Улаанбаатар хот, АСБИ ХК-ны байранд зохион байгуулав. Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 63456 ширхэг хувьцаа эзэмшдэг 58 хувьцаа эзэмшигчдээс 13 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн нь 61071 ширхэг хувьцаа буюу нийт саналын эрх бүхий хувьцааны 96.2% болж байх тул Компаний тухай хуулийн 69.1-т зааснаар ХЭХ хуралдуулах ирц бүрдэж хурал хүчин төгөлдөр болсныг тооллогын комиссын дарга Б.Доржсүрэн зарлав.

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
2. Компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт, ТУЗ-ийн дүгнэлт.
3. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн зардлын төсөв батлах.

“АСБИ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурал:

1. **Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг танилцуулах:** Тооллогын комиссын дарга Б.Доржсүрэн
 - а. ХЭХ-ийн ирцийг танилцуулья.
Ирц: 58 хувьцаа эзэмшигчдээс 13 хувьцаа эзэмшигч ирсэн. Нийт саналын 96.2% хувь болж байга тул хурал хүчин төгөлдөр болж байна.
2. **Хурал нээх**
Д.Лхагвасүрэн: Ээлжит хувьцаа эзэмшигчдийн хураллуулах ирц бүрдсэн тул ХЭХ-ийг нээснийг мэдэгдье.
3. **Хэлэлцэх асуудлыг батлах**
Танилцуулсан нь: Хурлын дарга Д.Лхагвасүрэн
Тайлбар: Хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.
4. **Хэлэлцэх асуудал 1:** 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах,
2018 оны санхүүгийн тайланг батлах эсэх тухай
Танилцуулсан нь: Хурлын дарга Д.Лхагвасүрэн
-2018 оны үйл ажиллагааг тайлагнасан POWER POINT танилцуулав.
Тайлбар: ТУЗ-ийн хурлаар Бэст Фортуна Аудитын компаний гаргасан хангалттай гэсэн дүгнэлтийг ТУЗ-өөс хүлээн зөвшөөрч, 2018 оны үйл ажиллагааны тайланг

хангалтай гэж дүгнэлт гаргасан. Энэхүү дүгнэлтийг батлахыг Хувьцаа эзэмшигч та бүхнээс санал хураахаар оруулж байна.

Санал хураалтын дүнг танилцуулах нь: Тооллогын комиссын дарга Б.Доржсүрэн

4.1 Зөвшөөрсөн 61071 ширхэг 100%

4.2 Татгалзсан 0 ширхэг 0%

4.3 Түтгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

5. **Хэлэлцэх асуудал 2:** Компаний ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах,

Танилцуулсан нь: Хурлын дарга Д.Лхагвасүрэн

Тайлбар: ХЭХ-д идэвхитэй оролцож байга та бүхэнд баяр хүргэе. ТУЗ-ийн 2018 оны үйл ажиллагааны танилцуулгын талаар танилцуулах POWER POINT-ийг хүргүүлж байна.

Ердийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг POWER POINT хэлбэрээр танилцуулав.

Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг POWER POINT хэлбэрээр танилцуулав.

Санал хураалтын дүнг танилцуулах нь: Тооллогын комиссын дарга Б.Доржсүрэн
Компаний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн сонгох санал хураалтын дүн:

5.1 Л.Сүмбанд 61071 ширхэг буюу 100%-ийн санал:

5.2 Д.Лхагвасүрэн 61071 ширхэг буюу 100%-ийн санал:

5.3 Ч.Дашцэрэн 60581 ширхэг буюу 98%-ийн санал:

5.4 Б.Должиндэмбэрэл 47241 ширхэг буюу 78%-ийн санал:

5.5 Б.Доржсүрэн 50120 ширхэг буюу 82%-ийн санал:

5.6 Л.Түвшинзаяа 46821 ширхэг буюу 76%-ийн санал:

Компаний Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн сонгох санал хураалтын дүн:

5.7 Э.Буянтогтох 36361 ширхэг буюу 59%-ийн санал:

5.8 Ц.Одончимэг 61071 ширхэг буюу 100%-ийн санал:

5.9 Л.Нямдаваа 22531 ширхэг буюу 36%-ийн санал:

байх тул Компаний тухай хуулийн 77.4 дэхь хэсэг, СХЗ-ны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-д зааснаар шийдвэр хүчинтэй.

6. **Хэлэлцэх асуудал 3:** Компаний ТУЗ-ийн 2019 оны төсвийн саналыг танилцуулах

Танилцуулсан нь: Д.Лхагвасүрэн

Тайлбар: Өнгөрсөн жилийн ТУЗ-ийн төсөвтэй ижил байхаар төсвийн саналыг оруулж байна.

Санал хураалтын дүнг танилцуулах нь: Тооллогын комиссын дарга Б.Доржсүрэн

6.1 Зөвшөөрсөн 61071 ширхэг 100%

6.2 Татгалзсан 0 ширхэг 0%

6.3 Түтгэлзсэн 0 ширхэг 0% байх тул Компаний тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн Хурлын тогтоолыг батлах

Танилцуулсан нь: Хурлын дарга Д.Лхагвасүрэн

Тайлбар: Тооллогын комиссын дээрх дүгнэлтийг үндэслэн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол тус бүрийг уншин танилцуулж батлав.

Ийнхүү хурлын дарга Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хаасныг мэдэгдэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



АСБН
ХК

Д. Окагвас

Д.ЛХАГВАСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

О.БИЛГҮҮН

ТАНИЛЦСАН:

М. Сумбуу
Ч. Дагвасүрэн

Ж.ХАЛЗАН

Л.СҮМБАНД

Ч.ДАШЦЭРЭН

М. Сумбуу
Д. Норовбадам

С.БАТ-ЭРДЭНЭ – 2

Д.НОРОВБАДАМ

Д.НОРВ

О.Бм

О.БАЯРДОРЖ

П.Эрдэнэжаргал
Ж.Цэрэнлхам

П.ЭРДЭНЭЖАРГАЛ

Ж.ЦЭРЭНЛХАМ

А.Тэмүүлэн

А.ТЭМҮҮЛЭН

Ц.Тэгшжаргал

Ц.ТЭГШЖАРГАЛ

О.Баяржаргал

О.БАЯРЖАРГАЛ